

**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ 2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь: Компанийн Төлөөлөн удирдах Зөвлөлийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

БҮРЭЛДЭХҮҮН:

Нэр дэвшүүлэх хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Мөнх-Эрдэнэ

Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Болод

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Наран-Учрал

Нэр дэвшүүлэх хороо нь 2 удаа хурал зохион байгуулж, хэлэлцсэн асуудалтай холбоотой дүгнэлт гаргаж, ТУЗ-д хурлын үр дүнгээ танилцуулсан бөгөөд хорооны чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч ажилласан.

2024 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх дуусгавар болсонтой холбогдуулан нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийг тодорхойлон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилсон. Тус хорооны бүрэлдэхүүнийг 2024 оны 05 сарын 24-ний өдрийн ТУЗ-ийн №10 тоот тогтоолоор баталсан.

Нэр дэвшүүлэх хороо нь чиг үүргийнхээ хүрээнд ТУЗ-ийн өөрийн үнэлгээ, ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажил үүрэгт үнэлэлт дүгнэлт хийлээ. Үүнд:

ТУЗ-ийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх нь:

Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаар сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2024 оны 05-р сарын 24-ний өдөр байгуулагдсан цагаас хойш 2025 оны 03-р сарын 14-ны өдрийг дуустал нийт 6 удаа /4 удаа биечлэн, 1 удаа цахим, 1 удаа эчнээ/ хуралдсан бөгөөд эдгээр хурлаар хэлэлцсэн асуудлыг нэгтгэвэл:

- Арилжааны банкнаас зээл авах, эрх баталгаажуулах тухай 6 шийдвэр,
- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, дүрэм журам, бодлогын бичиг баримт батлах, дүгнэлт гаргах, үүрэг даалгавар өгөх зэрэг асуудлыг шийдвэрлэсэн 8 тогтоол гаргаж, нийт 29 асуудал хэлэлцэж, үнэлэлт өгч ажиллажээ.

- Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн хуралд оролцсон байдлыг авч үзвэл:

№	ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2024 он /5 удаа/	2025 /1 удаа/	Нийт оролцоо	Ирцийн хувь
1	Л.Эрхэмбаяр	5	1	6	100 %
2	Б.Тунгалаг	4	1	5	83,3 %
3	Ж.Болд	5	1	6	100 %
4	Э.Баяржаргал	5	1	6	100 %
5	М.Болод	5	1	6	100 %
6	А.Бакей	4	1	5	83,3 %
7	Ө.Оргил-Эрдэнэ	5	1	6	100 %
8	Г.Мөнх-эрдэнэ	5	1	6	100 %
9	Ц.Наран-Учрал	4	1	5	100%

2024 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс компанийн санхүү, үйл ажиллагаанд хяналт тавьж, улирал бүр санхүүгийн тайлантай танилцаж, компанийн бизнес төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин удирдлагын багийг чиглүүлэн ажилласан.

Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг сайжруулах, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч нарынхаа эрх ашгийг хангах үүднээс шаардлагатай бичиг баримтыг батлах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх шийдвэрийг баталсан.

“Түмэн шувуут” ХК нь 2024 онд компанийн соёлыг сайжруулах, ажилчдын тогтвортой байдлыг хангах, үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангахад чиглэсэн үйл ажиллагааг шат дараатайгаар авч хэрэгжүүлсэн бөгөөд ТУЗ-ийн зүгээс эдгээр арга хэмжээг дэмжин шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлэх, цалинг үе шаттай нэмэгдүүлэх дээр анхаарч ажиллалаа.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн үүрэг оролцоо, идэвхи санаачлагын үр дүнг компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээтэй уялдуулан ойлгож болно. Өөрөөр хэлбэл ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэл хангалттай сайн байгаа тул КЗК-ийн үнэлгээ жил бүр хэвийн буюу эрсдэлгүй түвшинд үнэлэгдэж байна.

Компанийн тогтвортой үйл ажиллагааг өндөр чадвартай удирдлага, зохион байгуулалтаар тасралтгүй хангах хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Эрх бүхий албан тушаалтнуудын нөөцийг бүрдүүлэх, тухайн албан тушаалын зэрэглэлтэй уялдуулж сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшуулал, залгамж халааг бэлтгэхэд анхааран ажиллаж, компанийн “Залгаж халааны бодлого”-ыг баримтлан ажиллаж байна.

Компанийн гүйцэтгэх удирдлагад үнэлэлт дүгнэлт өгөх нь:

Компанийн гүйцэтгэх удирдлага нь гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлэн компанийн үйл ажиллагааны тасралтгүй хэвийн байдлыг ханган ажиллаж, шувууны аж ахуйн бүтээн байгуулалтыг цаг хугацаанд нь хийж гүйцэтгүүлэн ашиглалтанд оруулж чадсанаар үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн байна. Компанийн гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй нягт хамтран ажиллаж, ТУЗ-ийг байнга мэдээллээр хангаж, байгууллагын санхүү болон үйл ажиллагааны тайлан мэдээллийг холбогдох журамд заасны дагуу нээлттэй, ил тод, тэнцвэртэй байдлыг хадгалан цаг тухайд нь олон нийтэд хүргэх ажлыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх нь:

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Ёс зүйн хороонууд нь чиг үүргийнхээ хүрээнд бодлогын бичиг баримтыг боловсруулах, компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогын хэрэгжилтийг хянах зэрэг ажлыг хийж гүйцэтгэн тухай бүрт нь хороодын зүгээс дүгнэлт гарган танилцуулж ажилласан.

ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажилд үнэлэлт дүгнэлт өгөх нь:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хурлын мэдээлэл, хурлаар хэлэлцэх асуудал, холбогдох танилцуулга материалыг цаг тухай бүрт нь бэлтгэн боловсруулж, хурлыг зохион байгуулахын зэрэгцээ Төлөөлөн Удирдах Зөвлөл, гүйцэтгэх удирдлагын баг болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах ажлыг зөв зохион байгуулан ажилласан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал, ТУЗ болон дэргэдэх хороодын хурлаас гарсан шийдвэр, дүгнэлтийг зохицуулах байгууллага болон олон нийтэд мэдээллэх, бичиг баримтын бүртгэл хөтлөх, хурлын тэмдэглэл бичих зэрэг хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлж, ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зөв зохион байгуулж ажилласан гэж дүгнэж байна.